

“ШУВУУНЫ АЖ АХУЙ” АЙМГИЙН ДЭД ХӨТӨЛБӨР**Нэг. “Шувууны аж ахуй” аймгийн дэд хөтөлбөрийн өнөөгийн байдал**

Тус аймаг нь 1971 оноос эхлэн 3100 толгой шувуу үүнээс 2600 өндөглөгч тоолуулж эхэлсэн бол 2014 онд 37000 толгой хүрч байсан бөгөөд 2016 онд 17664 толгой шувуу тооллогод 1 аж ахуйн нэгж, 14 өрхөд нийт 12177 тахиаг үржүүлэн 5050 ширхэг өндөг, 3 тн мах үйлдвэрлэсэн байна.

Тус аймагт ХХААХҮЯ-наас 2011 оноос 2 аж ахуйн нэгжид сүрэг сэлбэх дэгдээхэй зээлээр олгон шувууны аж ахуйн үйл ажиллагаа өргөтгөж 37000 мянган толгойд хүрч байсан бол өдгөө нэг аж ахуйн нэгжид 11000 тахиа үржүүлж аймгийн хүн амын хэрэгцээг хангахаар ажиллаж байна.

Шувууны аж ахуй эрхлэгчдийн үйл ажиллагааг тогтворжуулахад бүрэн найрлагад тэжээлийн үйлдвэрлэлийн нэмэгдүүлэх, зах, зээлд чанарын шаардлага хангасан эрүүл аюулгүй бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг загвар аж ахуйн байгуулсан байна.

Сумдын газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд заагдсан бүс нутагт шувууны аж ахуй үржүүлж хүн амын өндөг, махны хэрэгцээ хангагдсан байна.

БӨДНӨ ШУВУУНЫ АЧ ХОЛБОГДОЛ:

Дэлхийн олон оронд бөднийн аж ахуй эрчимтэй хөгжиж байгаа бөгөөд бөднийн өндөг нь хамгийн их хэрэглэгддэг хүнсний бүтээгдэхүүний болсон байна.

Бөднө шувуу нь элдэв өвчинд нэн тэсвэртэй буюу дархлаатай учир хүнд өвчин халдаахгүйн тулд урьдчилан сэргийлэх тарилга хийлгүй үржүүлж болдог цорын ганц шувуу тул мах, өндөгнд нь ямар нэг эмийн бодис хуримтлахгүй давуу талтай.

Бөднө шувууны өндөг нь бактерийн болон хорт хавдрын эсрэг үйлчилгээтэй, биеийн эсэргүүцэх чадварыг идэвхжүүлдэг, эмчилгээний чанартай эрүүл мэндийн бүтээгдэхүүн юм.

Мөн аминдэм, аминхүчил болон органик гаралтай бичил элементээр баялаг, ходоод гэдэс ба зүрх судасны үйл ажиллагааг сайжруулж, хүний биенээс хүнд металлыг гадагшлуулдаг.

Лецитин ихээр агуулдаг болохоор хүнсэнд түүхийгээр нь хэрэглэхэд бие махбодод хуримтлагдсан холестерин түвшинг бууруулдаг биологийн бодисын цуглуулга болсон экологийн цэвэр бүтээгдэхүүн юм.

Хүний биед харшил үүсгэдэггүй учраас нэн ялангуяа хүүхэд багачуудад ашиг тустай, идэвхитэй хэлбэрээр агуулагдсан Д аминдэм нь хүүхдийг рахит өвчнөөс сэргийлнэ.

Настай хүмүүс тогтмол хэрэглэснээр үе мөчөөр нь өвдөхөө больж, үсний уг нь бэхжин, хараа сонсгол нь сайжирч, мэдэгдэхүйц эрүүл саруул болдог. Эрчүүд түүхийгээр нь тогтмол хэрэглэж заншвал биеийн тамир, чалх, бэлгийн чадавхад тун сайн гэдэг нь хэдийнээ нотлогдсон зүйл. Мөн атеросклероз буюу цусны ханын хатууралт, даралт ихсэх, гэдэс ходоодны өвчин, чихрийн шижин өвчин, харшил болон хүүхдийн диатез өвчинг бөднийн өндөгөөр амжилттай эмчилж байна.

Бөднийн өндгийг хүүхэд хоногтоо 2-6 ширхэг, томчуул 4-6 ширхгийг хүнсэндээ хэрэглэхийг зөвлөж байна. Тэгэхдээ өглөө өлөн биендээ түүхийгээр нь, бас бүлээн усаар даруулж, тогтмол буюу 3-4 сарын турш тасралтгүй хэрэглэнэ.

Бөднийн өндгийг 0-+20°C –ийн хэмийн ердийн нөхцөлд 25 хоног хадгалж болно. ОХУ-ын Биохимийн Хүрээлэнгийн судалгаанаас үзвэл бөднийн өндөгний нэг граммыг тахианд харьцуулахад,

- А аминдэм 1.5 дахин,
- В аминдэм 2.8 дахин,
- В2 аминдэм 2.2 дахин,
- Фосфор, кали 5 дахин,
- Төмөр, кальци 4 дахин,

Зэс, кобальт 2 дахин их агуулж байна.

Хоёр. Хөтөлбөр боловсруулах шаардлага. Үндэслэл

Манай аймагт үржүүлэгчид ихэвчлэн өрх гэрийн хэрэгцээг хангах бага хүчин чадал бүхий жижиг аж ахуйнууд зонхилж байна.

Хүн амын хүнсний хэрэгцээний тодорхой хэсэг болох өндөг, махны нөөц бүрдүүлэх зайлшгүй шаардлага тулгарч байгаа бөгөөд цогц хэлбэрээр загвар аж ахуй шинээр бий болгоход тахиан 2 чиглэлээр үржүүлэх хэрэгтэй.

1. Өндөгний аж ахуй
2. Махны аж ахуй

АЙМАГТАА ҮРЖҮҮЛЭХ ҮҮЛДЭР: “ИС БРОУН” КРОССЫН ӨНДӨГЛӨГЧ ТАХИАНЫ АШИГ ШИМИЙН ҮЗҮҮЛЭЛТ

Ашиг шимт чанар:

50 хувийн өндөглөлтөд хүрэх нас: 20 дахь 7 хоног

Оргил өндөглөлтөд хүрэх нас: 26 дахь 7 хоног

Оргил өндөглөлт хувь: 90

76 дахь 7 хоног дахь өндөглөлтийн хувь: 70

90 хувиас дээш өндөглөлттэй байх хугацаа 26 дахь 7 хоног

76 дахь 7 хоногийн ашиг шимийн үзүүлэлт:

Нэг өндөглөгчөөс авах өндөг: 250

Нэг өндөглөгчөөс авах өндөгний жин: 20 кг

Тэжээлийн төлц (кг/кг): 2,00

12 ширхэг өндгөнд ногдох тэжээлийн төлц: 1,50

Өндөгний хэмжээ:

Өндөгний жин 60 г-д хүрэх нас: 28 дахь 7 хоног

76 дахь 7 хоног дахь өндөгний жин: 50 кг

Өндөгний толгой хамгаалалт:

Сүрэг сэлбэх дэгдээхэй (18 дахь 7 хоног хүртэл): 90 хувь

Хэрэгцээний өндөглөгч тахианы толгой хамгаалалт: 85 хувь

Гурав. Хөтөлбөрийн зорилго, зорилгууд

3.1. Шувууны аж ахуйн үржлийн ажил, технологийг сайжруулж хүн амыг эрүүл аюулгүй баталгаажсан өндөг, махаар хангах;

3.2. Хөтөлбөрийн зорилгыг биелүүлэхийн тулд дараахь зорилтуудыг хэрэгжүүлнэ.

Үүнд:

3.2.1. Шувууны аж ахуйн мах, өндөг үйлдвэрлэлтийг нэмэгдүүлэх, зүй зохистой ашиглах, хамгаалах, эрүүл аюулгүй чанартай бүтээгдэхүүнээр хангах;

3.2.2. Бөднө шувууны аж ахуйг өргөжүүлэн хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх;

Дөрөв. Хөтөлбөр хэрэгжүүлэх үе шат

4.1. Энэ хөтөлбөрийг 2017-2025 оныг дуусталхи хугацаанд жил бүрийн ажлын төлөвлөгөөтэйгөөр хэрэгжүүлнэ.

4.2. Хөтөлбөрийг 2 үе шаттайгаар хэрэгжүүлнэ. Үүнд:

4.2.1. Эхний шат - 2017-2021 Шувууны аж ахуйн үйлдвэрлэлд дэвшилтэт технологи нэвтрүүлэх, үржил селекцийн ажлыг шинжлэх ухааны үндэслэлтэй явуулан өндөгний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, шувууны өвчнөөс урьдчилан сэргийлэхэд зүйн орчин бүрдэнэ.

4.2.2. Хоёр дахь шат - 2022-2025 Орон нутагтаа бөднө шувуу үржүүлэгчийг дэмжих, өндөг, мах үйлдвэрлэлийн хэмжээ нэмэгдүүлэх, эрүүл аюулгүй бүтээгдэхүүн борлуулах, нөөцийг нэмэгдүүлэх боломж бүрдэнэ.

Тав. Хөтөлбөр хэрэгжүүлэх удирдлага, зохион байгуулалт

5.1. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх асуудлаар аймгийн Засаг дарга, түүний Тамгын газрыг чиглэл өгсний дагуу мэргэжил арга зүйгээр хангах үүргийг Хүнс, хөдөө аж ахуйн газар, сумдын Мал эмнэлэг, үржлийн тасаг хүлээнэ.

5.2. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд жил бүр нэгдсэн төлөвлөгөөтэйгөөр зохион байгуулан, биелэлтийг гаргаж, үр дүнг тооцно.

5.3. Хөтөлбөрт шаардагдах санхүүгийн эх үүсвэрийг тооцон, батлуулж хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлэх асуудлаар санал боловсруулж, шийдвэрлүүлнэ.

Зургаа. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх хөрөнгийн эх үүсвэр, санхүүжилт

6. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд дараахь хөрөнгийн эх үүсвэрийг ашиглана.

6.1. Улсын болон орон нутгийн төсвөөс хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд зориулж олгох хөрөнгө

6.2. Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан

6.3. Сум хөгжүүлэх сан

6.4. Урт хугацаатай, хөнгөлөлттэй зээл

6.4. Олон улсын болон гадаадын байгууллагын хөрөнгө оруулалт, зээл тусламж

6.5. Иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын хандив, тусламж

6.6. Тухайн иргэн, аж ахуйн нэгжийн өөрийн хөрөнгө

Долоо. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээ

7.1. Хөтөлбөрийн зорилтуудыг хэрэгжүүлэхэд шувууны өндөг, махны үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх чиглэлээр шинжлэх ухаан технологийн ололтыг нэвтрүүлэн бүрэн механикжсан загвар аж ахуйн суурийг бий болгож зохион байгуулна.

7.1.1. Хөтөлбөрийн 3.2.1-д дэвшүүлсэн зорилтын хүрээнд дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлнэ. Үүнд:

7.1.1.1. Аймаг, сумдын бэлчээрийн төлөв байдлыг тогтоож, даацыг зөв тодорхойлсноор шувууны аж ахуйн үйлдвэрлэлийн оновчтой хэлбэр, тоо хэмжээний зохистой бүтцийг боловсруулан, сурталчилна.

7.1.1.2. Өндөр ашиг шимтэй шувуу үржүүлж бойжуулах нь хоногийн настай дэгдээхэйн арчилгаа маллагаа, дулаан, тэжээл, усны норм, технологийн горимыг баримтална.

7.1.1.3. Шувууны аж ахуй эрхлэгчид бүрэн найрлагад тэжээлийн ургамал тариалах газрын асуудлыг шийдвэрлэн өгөх боломжийг олгоно.

7.1.1.4. Шувууны тоо, толгой, хүчин чадлын байдал ажлын ачааллаас хамаарч, малын эмчтэй болгох, малын эмч нарт шувууны өвчний талаар мэргэжлийн байгууллага, эмч, багш нараар сургалт, сурталчилгааг зохион байгуулна.

7.1.1.5. Үржлийн сүрэг сэлбэлтийг холбогдох журмын дагуу зохион байгуулах мөн заал байр, сангасны талбайн ариутгал, халдваргүйтгэлийг мэргэжлийн байгууллагаар зориулалтын техникээр хийлгэнэ.

7.1.1.6. Аж ахуй эрхлэгч нарт зориулсан тайлан тооцоо, бүртгэл хөтлөлтийн журналыг мөрдөж ажилласан байна.

7.1.1.7. Вакцинд хамрагдах шувууны тоог нарийвчлан гаргах, вакцинжуулалтын ажлыг чанартай хийлгэх, вакцины дархлаажуулалтын хугацааг мэргэжлийн холбогдох байгууллагаар тогтоолгон тодорхой болгох, вакцины хугацаанд хяналт тавиулна.

7.1.1.8. Эрчимжүүлсэн аж ахуйн мал эмнэлэг, ариун цэврийн асуудлыг сайн шийдвэрлэснээр халдварт өвчин гарах магадлалыг бууруулахад мэргэжлийн малын эмч, мал зүйч ажиллуулна.

7.1.2. Хөтөлбөрийн 3.2.2-д дэвшүүлсэн зорилтын хүрээнд дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

7.1.2.1. Шувууны аж ахуйн үйлдвэрлэлийг эрчимжүүлэн ашиг орлогыг нэмэгдүүлэхэд шинэ арга, технологи нэвтрүүлэх чиглэлээр болон Мал эмнэлэг, үржлийн тасгийн мэргэжилтнүүд, төрийн бус байгууллага, иргэдтэй хамтран ажиллана.

7.1.2.2. Аймгийн хэмжээнд шинээр 1 загвар аж ахуйг байгуулахад Засгийн газрын болон орон нутгийн Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан, Сум хөгжүүлэх сангийн хөнгөлөлттэй зээл, Гадаад, дотоодын хөрөнгө оруулалтыг авах бүхий л боломжийг судлан хэрэгжүүлж, дэмжлэг үзүүлнэ.

7.1.2.3. Аж ахуй эрхлэгчид нарын хоорондоо хөрөнгө хүчээ нэгтгэн хорших, хамтын хөдөлмөр эрхлэх замаар өндөг үйлдвэрлэлийн хэмжээг нэмэгдүүлэх санаачилгыг дэмжин хөгжүүлнэ.

7.1.2.4. Зохих хууль тогтоомжийн дагуу арвин ашиг шимтэй Аж ахуйг даатгалд хамруулах арга хэмжээг авна.

7.1.2.5. Иргэд, аж ахуй нэгжүүдэд сурталчлан, аж ахуйн үйлдвэрлэлийн технологийн нийтийн сургалт, танилцах аялал зохион байгуулах, гарын авлага, зөвлөмж хэвлүүлэн сурталчилна.

7.1.2.6. Аж ахуй эрхэлж байгаа иргэд, аж ахуй нэгжийн хооронд үржлийн материал солилцох, үзэсгэлэн худалдааг зохион байгуулах ажлыг бодлогын хэмжээнд зохион байгуулна.

7.1.2.7. Сүүлийн үеийн шинэ техник, технологийг судлан нэвтрүүлэн бүрэн найрлагад тэжээлийн үйлдвэр байгуулан ажиллуулах санаачилгыг дэмжинэ.

7.1.2.8 Аж ахуйг хөгжүүлэхэд мэргэжлийн байгууллагатай хамтран ажиллана.

Найм. Хөтөлбөрийг хэрэгжүүлснээр гарах үр дүн

8.1. Энэхүү хөтөлбөрийг хэрэгжүүлснээр дараахь үр дүн гарна.

8.1.1. Аймгийн хэмжээнд 1 загвар аж ахуй байгуулан хөтөлбөрт тусгагдсан зорилтыг бүрэн хэрэгжүүлнэ.

8.1.2. Өндөг, махыг савлах, хаяглах, хадгалах, тээвэрлэх цогц асуудлыг бүрэн шийдвэрлэсэн байна.

8.1.3. Тэжээллэгийн асуудлыг дотооддоо шийдвэрлэх боломжоор хангагдсан байна.

8.1.4. Аж ахуйгаас авах үр, өгөөжийг дээшлүүлэхэд чиглэгдсэн хөрөнгө, санхүүгийн болон, технологийн асуудлыг шийдвэрлэснээр шувууны махны үйлдвэрлэлтийг нэмэгдүүлэн хүнсний багагүй нөөцийг бий болгоно.

8.1.5. Бүрэн найрлагад тэжээлийн үйлдвэрлэлийн хэмжээ нэмэгдүүлэх замаар материаллаг бааз суурийг нэмэгдүүлэн технологийн чанарын өөрчлөлт гарсан байна.

8.1.6. Аймгийн хүн амын хэрэгцээг чанартай бүтээгдэхүүнээр, жигд хангах асуудлыг сайжруулан өндөг, махны хэрэгцээг дотооддоо хангах боломж бүрдсэн байна.

8.1.7. Тогтмол үйл ажиллагаа явуулж байгаа иргэн, аж ахуйн нэгжийг урамшуулна.

Аймгийн Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс Хүнс, хөдөө аж ахуйн газар